



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 379

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг
шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Чингис хаан Олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 47,000,000.00 (дөчин долоон сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Чингис хаан Олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын дарга Г.Баасандорж, Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Т.Ган-Очир нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3. Тээврийн хэрэгслийг татвар төлөгчийн бүртгэл, улсын бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001221
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарын
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт
329

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ОРТОГГҮЙ, АШИГЛАЛТЫН
ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСАЛТ

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ОРТОГГҮЙ, АШИГЛАЛТЫН
ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСАЛТ

| Д/Д | Хуулийн этгээдийн нэр | Хөрөнгийн нэр | Үйлдвэрлэсэн отноо/Ашиглалтад орсон отноо | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг) | Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг) | Цашид ашиглах хуулийн этгээдийн нэр | Шилжүүлэх ашиглах хуатаа хуагаа /жил/эр/ |
|-----|--|--|---|---------------|----------------|--|---|---|--|--|
| 1 | Чингис хаан Олон улсын нисэх буудал дахь Гаалийн газар | Ниссан тина /Nissan teana/ арлын дугаар JN1BVUJ32Z0003862, улсын дугаар 96-32 ТӨН | 2011/2012 | 1 | ш | 47,000,000.00 | 5,000,000.00 | 5,000,000.00 | 2 | Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| | Нийт дүн | | | | | 47,000,000.00 | | 5,000,000.00 | | (дөчин долоон сая) |